



INNOVATION
INVESTMENT



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК

АГУУЛГА

1 .Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудал

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.
- ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах, нөхөн олгох.
- Компанийн шинэчилсэн дүрэм батлах.
- Компанийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл

6. Саналын хуудасны загвар

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАРЛАЛ

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Инновэйшн инвестмент” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04-р сарын 28-ны өдөр 15:00 цагт /<https://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

Цахим хурал зохион байгуулах холбоос: <https://agm.mn/>

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр:
2025 оны 04-р сарын 08-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.
2. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах, нөхөн олгох.
3. Компанийн шинэчилсэн дүрэм батлах.
4. Компанийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах.

Хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид саналаа бүртгэлтэй брокер, дилерийн компаниар дамжуулах, компанийн байранд биеэр ирж цаасаар өгөх боломжтой. Урьдчилан санал авах сүүлчийн хугацааг 2025 оны 04 сарын 27-ны өдрийн 15:00 цагаар тасалбар болгоно. Аж ахуй нэгжийг төлөөлөн хуралд орлцох хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл урьдчилан хурал зохион байгуулах комисстой холбогдон тодруулага, мэдээлэл авна уу.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг хурал зохион байгуулах комиссын утсаар холбогдон авна уу.

Холбоо барих: 75551919, 80498649, 88105800

Мэйл хаяг: boardsecretary@qpay.mn

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

“Инновэйшн Инвестмент” ХК-ийн Төлөөлөн
удирдах зөвлөлийн хурлын 2025 оны 03
дугаар сарын 17-ны өдрийн 05/32 тоот
тогтоолын 2 дугаар хавсралтаар батлав.

1	Хурлын ирцийг бүртгэх (ажлын хэсэг)	15:00-15:10
2	Хурлын ирцийг мэдээлэх (ажлын хэсэг)	15:10-15:15
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	15:15-15:20
4	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах	15:20-16:00
5	Хувьцаа эзэмшигчид үг хэлэх, санал гаргах	16:00-16:20
6	Санал хураалт	16:20-16:40
7	Хурлын завсарлага	16:40-16:50
8	Тооллогын комисс санал хураалтын нэгдсэн дүнг гаргаж, комиссын дарга дүнг танилцуулах	16:50-17:00
9	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	17:00-17:10
10	Хурлыг хаах (хурлын дарга)	17:10-17:15





INNOVATION
INVESTMENT



Компанийн 2024 оны үйл ажиллагааны
болон санхүүгийн тайлангийн талаарх
ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн
батлах.

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

01





INNOVATION
INVESTMENT



2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

УЛААНБААТАР 2025 ОН



АГУУЛГА

01. КОМПАНИЙН ТУХАЙ

Компанийн тухай
Группийн бүтэц
Түүхэн замнал
Онцлох тоон үзүүлэлт
Онцлох санхүүгийн үзүүлэлт
2024 оны Онцлох үйл явдал

02. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төлбөрийн зах зээлийн тухай
QRAY ЭКО СИСТЕМ
Группийн дунд хугацааны төлөвлөгөө
Нийгмийн хариуцлага

03. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Ерөнхий мэдээлэл
ТУЗ-ийн үйл ажиллагаа
ТУЗ-ийн гишүүд
Гүйцэтгэх удирдлагын баг
Компанийн бүтэц
Хувьцааны мэдээлэл

04. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлан
Орлого үр дүнгийн тайлан
Өмчийн өөрчлөлтийн тайлан
Мөнгөн гүйлгээний тайлан

КОМПАНИЙН ТУХАЙ

Компанийн тухай

Группийн бүтэц

Түүхэн замнал

Онцлох тоон үзүүлэлт

Онцлох санхүүгийн үзүүлэлт

2024 оны Онцлох үйл явдал

01





КОМПАНИЙН ТУХАЙ

Инновэйшн Инвестмэнт ХК нь 2017 оноос хойш технологийн хурдацтай хөгжилд тулгуурлан иргэдийн өдөр тутмын амьдралын хэв маягийг хялбаршуулах зорилгоор санхүү, төлбөр тооцоо, мэдээлэл технологийн чиглэлээр шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт, менежментийн чиглэлээр үүсгэн байгуулагдсан олон нийтэд нээлттэй хувьцаат компани юм.

Инновэйшн Инвестмэнт ХК нь группийн хэмжээнд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжүүлэлт, хөрөнгө оруулалт, тэлэлтийн үйл ажиллагааг хариуцан ажилладаг ба QPay үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааг удирдах “ККТТ” ХХК, Мерчантуудад чиглэсэн үйлчилгээнүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах “Дижитал Мерчант Сервисэс” ХХК гэсэн хоёр охин компанитай үйл ажиллагаа явуулж байна.

Инновэйшн Инвестмэнт ХК-ийн QPay үйлчилгээ нь Монгол улсад хамгийн өргөн хэрэглээтэй дотооддоо хөгжүүлсэн төлбөр тооцооны системд зүй ёсоор тооцогддог ба 2024 онд өдөрт дунджаар 30 тэрбум гаруй төгрөгийн дүнтэй 500 мянга орчим гүйлгээг дамжуулж байна.

Инновэйшн Инвестмэнт ХК нь стратегийн хүрээнд шинэлэг шийдэлд хөрөнгө оруулах, дэмжлэг үзүүлэх, инновацлаг төслүүдийг дотооддоо хэрэгжүүлж зах зээлд гаргах менежментийн үйл ажиллагаагаар дагнан ажиллаж байна.



АЛСЫН ХАРАА

Хүний амьдралыг таатай болгох дижитал шийдэлд хөрөнгө оруулалт хийж, тогтвортой ирээдүйг бүтээх үйлсэд хувь нэмрээ оруулна.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Технологид суурилсан инновацлаг шийдэлд зохистой хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлж, шинэ үеийн нийгэм, хүмүүсийн амьдралын хэв маягт нийцсэн дижитал дэд бүтцийг бүрдүүлэх үйлсийг манлайлна.



ҮНЭТ ЗҮЙЛС

- Тэмүүлэл
- Хүчтэй түншлэл, харилца
- Багийн ажиллагаа
- Хариуцлага
- Ухаалаг
- Хэрэгцээг ойлгодог
- Тэнцвэртэй байдал
- Тогтвортой хөгжил



КОМПАНИ БҮТЭЦ



ТҮҮХЭН ЗАМНАЛ



2016

QR кодоор төлбөр хийх анхны хөгжүүлэлтийг дуусгаж, Хаан Банкинд хэрэгжүүлэх гэрээг байгуулсан.

2017

Анхны хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлэх зорилгоор Группийн толгой компани болох 'ИнновэйшнИнвестмент' ХК байгуулагдсан.

2020

Мерчантууд QR нэхэмжлэх үүсгэх боломжтой API-ийн 2.0 хувилбарыг шинээр нэвтрүүлсэн. UnionPay International-тэй хамтын ажиллагааг эхлүүлж, тэдний картын системд холбогдсон

2019

POS/кассын систем хөгжүүлэлтийн хүрээнд үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан шинэ POS API-г боловсруулж, нэвтрүүлсэн.

2018

Мерчантууд болон үйлчилгээ үзүүлэгчид үйлчлүүлэгчдэд зориулан QR нэхэмжлэх үүсгэх боломжтой API-ийн 2.0 хувилбарыг нэвтрүүлсэн

2022

Хятадад хамгийн өргөн хэрэглэгддэг (64 улсад ашиглагддаг) цахим төлбөрийн систем болох WeChat Pay-тэй экосистемийн гэрээ байгуулж, тус үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлсэн.

2023

Технологийн салбарт анх удаа IPO-г амжилттай хийж гүйцэтгэсэн.

2024

Өмнөд Солонгосын №1 цахим төлбөрийн систем болох GLN International-тай хамтран, Өмнөд Солонгосын жуулчдад QPay QR кодыг сканердаж, тухайн улсынхаа төлбөрийн аппуудаар Монгол Улсад төлбөр хийх боломжийг олгосон.

ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТ

ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ БА ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2024 он бол гүйлгээний тоо, гүйлгээний үнийн дүн болон борлуулалт зэрэг бүхий л статистик үзүүлэлтийн хувьд өндөр өсөлттэй жил байлаа.

Нэгж гүйлгээний
дундаж үнийн дүн

+23.9%

60,024 MNT

Өдрийн дундаж
гүйлгээний үнийн дүн

16.1 ТЭРБУМ
ТӨГРӨГ



Өдрийн дундаж
гүйлгээний тоо

482.2 МЯНГАН
ШИРХЭГ



Сарын дундаж
гүйлгээний тоо

14.7 САЯ
ШИРХЭГ




Сарын дундаж
гүйлгээний үнийн дүн


883.5 ТЭРБУМ
ТӨГРӨГ






ГҮЙЛГЭЭНИЙ ТОО /мянган ширхэг/
ЖДӨХ (2021-2024): 81.4%; УТД: 45.5%



ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН /тэрбум.төг/
ЖДӨХ (2021-2024): 102.4%; УТД: 80.3%




ІРО ХИЙХ ҮЕИЙН ТӨСӨӨЛӨЛ БА ГҮЙЦЭТГЭЛ



ОНЦЛОХ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

1. ОРЛОГЫН ТАЙЛАН	2023	2024	Жилийн өсөлт %
Борлуулалтын орлого	13,237,510,103	26,231,629,402	98%
Нийт ашиг	7,196,495,560	14,180,583,973	97%
Тайлант үеийн цэвэр ашиг	5,696,163,389	10,026,153,601	76%
2. БАЛАНС	2023	2024	Жилийн өсөлт %
Эргэлтийн хөрөнгө	17,864,868,924	18,726,231,800	5%
Эргэлтийн бус хөрөнгө	898,855,241	2,985,144,561	232%
Нийт хөрөнгө	18,763,724,165	21,711,376,362	16%
Нийт өр төлбөр	1,316,156,440	6,431,459,821	389%
Нийт эздийн өмч	17,447,567,724	15,279,916,540	-12%
Нийт эздийн өмч ба өр төлбөр	18,763,724,165	21,711,376,362	16%
3. МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2023	2024	Жилийн өсөлт %
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	3,911,403,450	8,794,939,633	125%
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(375,793,028)	(1,634,036,057)	335%
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн	8,610,849,157	(6,510,084,073)	-176%
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	12,146,459,579	653,778,597	-95%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,853,360,285	13,999,819,864	655%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,999,819,864	14,653,598,461	5%
4. САНХҮҮГИЙН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2023	2024	
Нийт ашгийн хувь	54.36%	54.06%	
Цэвэр ашгийн хувь	43.03%	38.22%	
Өөрийн хөрөнгийн өгөөж	32.65%	65.62%	
Авлагын эргэц	9.27	10.73	
Эргэлтийн харьцаа	19.88	6.27	
Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	13.96	2.94	

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ




ПОС-ийн системүүдэд Динамик QR үүсгэх хөгжүүлэлтийг дуусгав

ПОС-ийн системүүдэд холболт хийх API хөгжүүлснээр бүх ПОС төхөөрөмж дээр динамик QR үүсгэж төлбөр хүлээн авдаг болсон. Энэхүү холболтын үр дүнд ПОС төхөөрөмжтэй Динамик холболттой мерчантын тоо нэмэгдэж, бизнесийн орлогын гүйцэтгэлийг хангахад чухал нөлөө үзүүлсэн.



QPay x SocialPay

Голомт банкны SocialPay апп-аар QPay QR буюу QPay мерчантууд дээрх QR-ийг уншуулан гүйлгээ хийх, Голомт банкны QR-ийг QPay уншиж гүйлгээ хийх хөгжүүлэлтийг хийж, QPay нэвтэрсэн бүх банкны апп болон воллет, финтек апп-ууд Голомт банкны мерчантийн QR-ийг унших боломж бүрдсэн. Ингэснээр Монгол улсын бүх арилжааны банк QPay-ээр бүрэн төлбөр тооцоо дамжуулдаг болсон.



“EASY INVOICE” үйлчилгээг нэвтрүүлэв

Онлайн худалдааны салбарт буюу Facebook сошиал орчинд худалдаа хийж байгаа байгууллага болон хувь хүмүүсийн бизнест бодитой дэмжлэг болохоор төлбөрийн нэхэмжлэхийг гар утасны дугаарт мессеж хэлбэрээр илгээх, төлбөр хянах мэдэгдэл бүхий цоо шинэ үйлчилгээг нэвтрүүлсэн. Нэхэмжлэхийг SMS, Email-ээр илгээх, төлбөр хүлээн авах боломжтой динамик линк бүхий Easy Invoice үйлчилгээний хөгжүүлэлтийг бүрэн дуусгаж бодит орчинд нэхэмжлэхүүд илгээн, төлбөр хүлээн авах тестийг амжилттай хийж гүйцэтгэсэн. Ингэснээр тус бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах бүрэн боломжтой болсон.



Хэрэглээний төлбөрийн “BPay” үйлчилгээг нэвтрүүлэв

Төрийн банк ХК-тай хамтран Төрийн банкны системд бүртгэлтэй СӨХ, Контор, Цахилгаан түгээх байгууллагууд болон бусад үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын системийг нэгтгэн финтек аппликэйшнууд болон банкны аппликэйшнуудад нэвтрүүлж тэдгээрийн хэрэглэгчдэд хэрэглээний төлбөрөө төлөх боломжийг илүү ойртуулах томоохон бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн. BPay үйлчилгээг өнөөдрийн байдлаар Гэрэгэ компанийн +270 киоскуудад нэвтрүүлсэн ба Monpay, Toki, Тэсо Пропертийс, Pocket гэсэн мерчантуудад холбож хэрэглээнд нэвтрүүлсэн.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

МХБ II ангилалд дэвшин арилжаалагдаж эхлэв

Инновэйшн Инвестмент ХК-ийн QPAY симболтой үнэт цаас МХБ-ийн ангилал ахих шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж IPO хийснээс хойш нэг жилийн ойн дээрээ буюу 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн МХБ-ийн II ангилалд арилжаалагдаж эхэлсэн.

Хувьцаа эзэмшигчдэдээ 7'697'783'200₮ ногдол ашил олгов

Инновэйшн Инвестмент ХК нь IPO хийснээс хойш хувьцаа эзэмшигчдэдээ Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 15-ны 02/02 тоот тогтоолоор 4 тэрбум төгрөг, 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 05/14 тоот тогтоолоор 3'697'783'200₮, нийт 7'697'783'200₮-ийн ногдол ашгийг тус бүр олгосон.

Монголбанк QRC стандартыг амжилттай нэвтрүүлэв

Монголбанкнаас баталсан “QR кодын мессеж бүтэц, заавар”-ын дагуу нийт ашиглагдаж байсан системийн холболт бүхий мерчантын холболтонд системийн өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн ба 85'000 мерчант талаас нэмэлт хөгжүүлэлтийн зардал болон цаг хугацааны эрсдэл гаргахгүй байхаар тооцоолж, зөвхөн QPay системийн талаас шинэчлэл, өөрчлөлтүүдийг бие даан хийж амжилттай нэвтрүүлсэн.

Нөөц датацентр үүсгэж, найдвартай ажиллагааг хангав

QPay төлбөрийн систем бүхэлдээ эсвэл зарим бүрдэл хэсгүүд бодит цагийн горимоор болон гар аргаар нөөц датацентр лүү шилжин ажиллах техникийн төлөвлөлтийг боловсруулж, өөр байршилд шилжүүлэв. Үндсэн болон нөөц датацентрийн хоорондох сүлжээний холболтын найдвартай байдлыг хангах, Монголбанкны шаардлагад нийцүүлэх төлөвлөлтийг хийж шаардлагатай тоног төхөөрөмжийн суурилуулалтыг хийж дуусгав.

WechatPay төлбөрийн систем

Үнэт цаас гаргагч нь БНХАУ-ын хамгийн өргөн хэрэглээтэй төлбөрийн аппликэйшн болох WeChat Pay үйлчилгээг нэвтрүүлснээс хойш багагүй хугацаа өнгөрсөн ба Монгол улсын Гадаадын Иргэн Харьяатын Газарын цахим үйлчилгээнд системийн холболт хийж Монгол улс руу зорчих цахим виз, оршин суух эрх зэрэг түгээмэл авдаг үйлчилгээний төлбөрийг цахимаар шийдсэнээр гадаадын иргэдэд орон цай, цаг хугацаа хамаарахгүйгээр үйлчилгээ авах нөхцөлийг бодитойгоор бүрдүүлсэн.

GLN International-тэй системийн холболтыг дуусгав


2024 оны 6 дугаар сард SendMN-тэй хамтарч БНСУлсын GLN International групптэй системийн холболт, хөгжүүлэлтийг хийж дуусган эхний ээлжинд БНСУлсын иргэд QPay мерчантууд дээр өөрийн улсад ашигладаг төлбөрийн аппликэйшнээр QR код уншуулан төлбөр тооцоо хийх боломжтой болсон.

PCI DSS стандартын шаардлагыг хангав

Картын мэдээллийн аюулгүй байдлын PCI DSS стандартын шаардлагыг бүрэн ханган БНЭУ-ийн SISA байгууллагаар дөрөв дэх жилдээ амжилттай баталгаажилт хийлгэв. Энэ хүрээнд жилд 4 удаагийн эмзэг байдлын үнэлгээ хийлгэн, картын мэдээллийг аюулгүй, нууцлалтай хадгалах, дамжуулах ажлыг тухай бүр хийж ажилласан.

ISO 27001:2013 стандартын баталгаажилтыг хангав

Олон улсын Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 27001:2013 стандартыг Франц улсын Фнор байгууллагаар амжилттай баталгаажилт хийлгэн 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр гэрчилгээ хүлээн авсан. Стандартын хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын тогтолцооны шаардлагыг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөн ажиллаж байна.



INNOVATION
INVESTMENT



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төлбөрийн зах зээлийн тухай

QPAY ЭКО СИСТЕМ

Группийн дунд хугацааны төлөвлөгөө

Нийгмийн хариуцлага

02



ТӨЛБӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ

Монгол Улсын төлбөрийн системийн эрх зүйн орчныг шинэчлэх ажлын хүрээнд “Үндэсний төлбөрийн системийн тухай хууль” 2017 оны 5 дугаар сарын 31-нд батлагдаж, 2018 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөгдөж эхэлсэн. Энэ хууль нь Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг удирдах, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахаас гадна Үндэсний төлбөрийн системд банкнаас бусад этгээд оролцох боломжийг нээж өгсөн байдаг.

Төлбөр тооцооны системийн үндсэн зорилго нь банк, санхүүгийн салбарт хийгдэж буй төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай, шуурхай гүйцэтгэх замаар нийт эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг хурдасгах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах явдал юм. Иймд төлбөрийн систем нь санхүүгийн системийн дэд бүтцийн чухал хэсэг төдийгүй мөнгөний бодлогыг дамжуулах гол суваг болж үйлчилдэг. Сүүлийн жилүүдэд өндөр түвшний технологи нэвтрэхтэй зэрэгцэн зах зээлийн хөгжлийн хандлага, эрэлт шаардлагад нийцсэн бэлэн бус төлбөрийн шинэ дэвшилтэт хэрэгслүүд хурдацтайгаар бий болж, төлбөр тооцоог түргэн шуурхай, үр ашигтай гүйцэтгэх боломж бүхий шинэ системүүдийг нэвтрүүлэхэд хүргэсэн. Эдгээр системийн үр ашигтай, хэвийн ажиллагаа нь байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, бизнес эрхлэгчдэд санхүүгийн үүргээ биелүүлэх, мөнгөн хөрөнгөө аюулгүй, цаг тухайд нь шилжүүлэх боломжийг олгож байна.


Өнөөдрийн байдлаар төлбөр тооцооны зах зээл дээр доорх үндсэн оролцогчид байна:

- Монголбанк: Зохицуулалт болон Арилжааны банк хоорондын сэтгэлэмэнт, клиринг гүйцэтгэнэ.
- Арилжааны банкнууд: Хадгаламж, зээл, санхүүгийн үйлчилгээ, төлбөрийн карт, цахим хэтэвч, банкны төлбөрийн аппликейшн гэх мэт үйлчилгээ үзүүлж байна.
- Бусад зээлдүүлэгчид болон финтек платформууд: Уламжлалт болон финтекд суурилсан Банк бус санхүүгийн байгууллагууд нь зээл, лайфстайл платформ, цахим хэтэвч, санхүүгийн бүтээгдэхүүнүүд гарган үйлчилж байна. Мөн Buy Now Pay Later үйлчилгээ үзүүлэгчид, Монголбанкнаас цахим мөнгөний зөвшөөрөл авсан финтек платформ багтаж байна.




БЭЛЭН БУС ТӨЛБӨР ТООЦООНЫ ЗАХ ЗЭЭЛ

МУ-ын бэлэн бус гүйлгээний тоо, үнийн дүн



QPay зах зээлд эзлэх хувь



—●— Гүйлгээний дүн /тэрбум төгрөг/

- 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт бэлэн бус гүйлгээний тоо 2.1 тэрбум ширхэгт хүрч өмнөх оноос 15.6% өссөн бол үнийн дүнгийн хувьд 576 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 29.8% хувиар өсөхөөр байна.
- QPay үйлчилгээгээр хийгдэж буй гүйлгээнүүд нь тогтмол өсч 2023 оны эцсээр нийт бэлэн бус төлбөр тооцооны зах зээлийн 6.9 хувийг эзэлж байсан бол 2024 онд зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлсэний үр дүнд 8.6 хувьд хүрэх хүлээлттэй байна.

ДИЖИТАЛ ТӨЛБӨР ТООЦООНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

ДИЖИТАЛ ХЭТЭВЧ БА ГАР УТАСНЫ ТӨЛБӨР ТООЦОО

- Дижитал хэтэвчийн өсөлт
- Супер АПП
- Embedded Payments

Contactless Payment

- Тав тух, аюулгүй байдал
- NFC, Tap-and-Pay

ОДОО АВААД ДАРАА ТӨЛ (BNPL)

- PayPal зэрэг том брэндүүд хөрөнгө оруулалт хийж эхэлсэн
- Залуу үеийн хэрэглэгчид түгээмэл ашиглаж байна.

Cryptocurrency Payments

- Кripto төлбөр тооцоо
- Stablecoins

ХИЛ ДАМНАСАН БОЛОН ОЛОН УЛСЫН ТӨЛБӨР

- Блокчэйн технологийг ашиглан илүү хурдан, хямд шилжүүлэг хийж байна.
- Төлбөрийн брэндүүд олон улсад зах зээлээ тэлж байна.

AI and Machine Learning Payment

- Залилан илрүүлэх
- Хэрэглэгчийн санхүүг оновчтой болгох

Open Banking and API Integration

- API-д суурилсан системийг түгээн дэлгэрүүлэх
- Түүнд суурилсан шинэ үйлчилгээг хөгжүүлэхэд анхаарч байна.

Real-Time Payments and Instant Transfers

- Бодит цагийн төлбөр тооцооны сүлжээ
- Төлбөр системүүд болон банкуудын хамтарсан шуурхай шилжүүлэг

Sustainability and Ethical Payments

- Хэрэглэгчид өөрсдийн гүйлгээгээр байгаль орчиндоо санаа тавих шийдлийг сонгож байна.

QR КОДЫН ТӨЛБӨР ТООЦОО

- Азийн орнуудад хамгийн түгээмэл, төлбөр хүлээн авах хялбар арга
- Visa, Mastercard брэндүүд QR төлбөрийг нэвтрүүлж байна.

DECENTRALIZED FINANCE (DEFI) & BLOCKCHAIN

- DeFi платформууд
- Виза зэрэг брэндүүд төвлөрсөн бус блокчэйн суурилсан төлбөрийн шийдлүүдийг судалж байна.

LOYALTY PROGRAMS AND REWARDS INNOVATIONS

- Loyalty programs & Cash-back
- Худалдаа үйлчилгээ үзүүлэгчидтэй хамтарч, төлбөр тооцоог идэвхжүүлж байна.

Tokenization and Data Security

- Visa, Mastercard зэрэг брэндүүд токенжуулалтыг ашиглаж байна.
- Biometric Payments

ТҮНШЛЭЛ БА ЭКОСИСТЕМИЙН ӨРГӨЖИЛТ

- Төлбөрийн брэндүүд экосистемээ өргөжүүлж, финтек, SME, технологийн компаниудтай стратегийн түншлэл үүсгэж байна.

B2B Payments

- B2B төлбөр тооцоо нь дэлхийн төлбөрийн зах зээлийн томоохон хувийг бүрдүүлж байна.

QPay нь **QR кодоор төлбөр хийх**, апп дотрох төлбөрийн шийдэл, вэб суурьтай төлбөрийн системд мэргэшсэн технологийн компани юм.

Бид Монгол Улсын бүх арилжааны банкууд болон финтек компаниудтай төлбөрийн системээ холбосон бөгөөд бизнесүүд болон хэрэглэгчдэд хамгийн хялбар, найдвартай төлбөрийн шийдлийг санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН
ХҮН АМЫН ТОО**

3.5 сая

QPAY ХЭРЭГЛЭГЧИД


+3 сая

**ЖИЛИЙН
ГҮЙЛГЭЭНИЙ ТОО**

176.6 сая

**ЖИЛИЙН
ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН**

10.6 их наяд



Инновэйшн Инвестмэнт ХК-ийн амжилттай хөгжүүлсэн төсөл болох QPay үйлчилгээ нь өдгөө Монгол улсын бүх арилжааны банк, финтек, воллет апп-уудад нэвтрэн хэрэглэгч мерчантуудад хүссэн апп-аараа төлбөр тооцоо хийх, төлбөрийн хэрэгслийн сонголтот байдлыг аюулгүй, найдвартай, түргэн шуурхайгаар хүргэн ажиллаж байна.

ГРУППИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

БЭЛЭН БУС ТӨЛБӨР ТООЦООНЫ ЗАХ ЗЭЭЛД БАЙР СУУРИА БЭХЖҮҮЛЭХ, ХАРААТ БУС БАЙДЛЫГ БИЙ БОЛГОХ

Группийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хүрээнд дотоодын нийт төлбөр тооцооны зах зээлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх, түүний дотор мерчантад чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтыг нэмэгдүүлэх, мерчантын датад суурилан хэрэгцээт бүтээгдэхүүн үйлчилгээг шинээр хөгжүүлж санал болгох байдлаар идэвхтэй харилцагчийн тоог нэмэгдүүлэхэд чиглэн ажиллахаар төлөвлөж байна. Энэ хүрээнд дунд хугацаанд үндсэн 8 чиглэлд голчлон анхаарч ажиллана.

01. ДОТООДЫН ТӨЛБӨР ТООЦООНЫ ЗАХ ЗЭЭЛ ЭЗЛЭЛТИЙН ӨСӨЛТ

Төлбөр тооцооны зах зээлийн өрсөлдөөний хурдтай өсөлт, шинэ төрлийн төлбөрийн системүүд үйлчилгээнүүд, олон улсын томоохон төлбөрийн системүүд (Apple Pay, Alipay, WeChat гэх мэт) Монгол улсад эрчимтэйгээр нэвтэрсээр байна. Төлбөр тооцооны зах зээлд байр сууриа бэхжүүлэх, гэнэтийн хүчин зүйлсийн бизнест нөлөөлөх хамаарлыг бууруулах, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, брэндинг, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.

02. МЕРЧАНТЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТЭЛЭЛТ

Технологийн хурдтай хөгжил, хэрэглэгчийн амьдралын хэв маягийн өөрчлөлттэй уялдан шинэ төрлийн бизнесүүд улам бүр нэмэгдэж байна. Инновэйшн Инвестмент ХК нь Qpay үйлчилгээний харилцагчийн дата мэдээлэлд үндэслэн сегментчлэлийг нарийвчлан тодорхойлж, шинээр бий болж буй бизнесүүдийг өөрийн мерчант болгох тал дээр идэвхтэй ажиллаж байна. Түүнчлэн харилцагч болох алхмуудыг хялбарчилж цахим гэрээ байгуулах, хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлэх, мерчант элсүүлэлтийг зайнаас хийх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

03. МЕРЧАНТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖСЭН ХАРИЛЦАН АШИГТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Харилцагчийг танин мэдэх процессийг сайжруулах, түүнтэй хамааралтай шинэлэг CRM, Omnichannel гэх мэт системүүдийг нэвтрүүлж, харилцагчийн эрэлт хэрэгцээг тодорхойлох судалгаануудыг тогтмол хэрэгжүүлж эхлээд байна. Мөн харилцагчийн датад үндэслэн хэрэгцээг илрүүлэх, техникийн боломжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна. Харилцагчийн судалгаа болон өгөгдөлд суурилсан анализийг хослуулж, харилцан ашигтай бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгоход төвлөрөн ажиллаж байна.

04. ОЛОН УЛСЫН ТӨЛБӨР ТООЦООНЫ ГАРЦЫН ӨСӨЛТ

2024 оны 11 сарын байдлаар Монгол улсаас гадаад улс оронд аялсан иргэдийн тоо 1.2 саяд хүрч, 500 сая ам.долларын худалдан авалт хийсэн байна. 2024 оны эхний 10 сарын байдлаар Монгол улсад ирсэн жуулчдын тоо 500'000 орчимд хүрсэн ба нэг жуулчин дунджаар 1500 ам.доллар зарцуулдаг бөгөөд нийт 750 сая ам.долларын гүйлгээ хийжээ. Эдгээр гүйлгээг ихэвчлэн Visa, MasterCard, UnionPay зэрэг олон улсын төлбөрийн картуудаар хийдэг байна. Qpay үйлчилгээний олон улсын төлбөр тооцооны чадамжийг нэмэгдүүлж, дотоод гадаадад дурын төлбөрийн апп-аар Qpay уншуулан төлбөр тооцоо хийх боломжийг үе шаттайгаар нэвтрүүлэн ажиллаж байна.



ГРУППИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

05. ТЕХНОЛОГИЙН ЧАДАМЖИЙН ӨСӨЛТ

Хиймэл оюун ухаан бизнесийн бүхий л үйл ажиллагаанд хэрэглэгдэж эхэлсэн ба тэр дундаа Монгол байгууллагуудад харилцагчийн үйлчилгээ, цахим залилан, зээлийн үнэлгээ, гүйлгээний эрсдэл, тээвэр логистик, онлайн худалдаа үйлчилгээний салбарт түгээмэл ашиглагдаж байна. Инновэйшн Инвестмент ХК нь 2025 онд өгөгдөл цуглуулах, хадгалах, боловсруулах суурь дэд бүтцээ сайжруулж, байгууллагын хэлтэс бүрд нэн шаардлагатай дэвшилтэт системүүдийг нэвтрүүлэх, технологийн чадамжийг тасралтгүй сайжруулах тал дээр анхаарч ажиллаж байна.

06. ОРЛОГЫН УРСГАЛЫН ТӨРӨЛЖИЛТ

Бизнесийн орлого бүрдүүлэлтийн төрөлжилтийг нэмэгдүүлэхийн тулд 2024 онд зах зээл, чиг хандлагын суурь судалгааг хийж, түүнд тулгуурлан 2025-2027 оны хооронд хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулсан. Энэ хүрээнд 2024 онд багтаан брэндийн бодлогыг шинэчилж, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн дунд хугацааны төлөвлөгөөг гарган хөгжүүлэлтийн ажлуудыг үе шаттайгаар эхлүүлээд байна.

07. ХАРИЛЦАГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

Харилцагчийн үйлчилгээний бүх сувгуудад OMNICHANNEL нэвтрүүлж, холбогдсон түүхүүдийг дэлгэрэнгүй бүртгэх дэвшилтэт CRM систем нэвтрүүлэх төслийг эхлүүлээд байна. Мерчант, харилцагч байгууллагуудын сэтгэл ханамжийн судалгааг мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэж, процессийн алдааг илрүүлэх, харилцагчид үйлчлэх журам стандартыг тогтмол сайжруулж, харилцагчийн сэтгэл ханамжийг өндөр байлгах тал дээр анхаарч ажиллана.

08. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Нөхцөл байдал: Банкны 1 гүйлгээний ард 1 ширхэг А4 цаас ашиглагддаг гэж үзвэл QPaу үйлчилгээ нь 2024 онд 176,6 сая ширхэг цаас хэмнэснээр 21'208 мод, 65'117 тонн ус, 3'000м3 нүүрс хүчлийн хийн ялгаруулалтыг тус тус хэмнэсэн байна. Үүнээс гадна Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй цахим бизнесүүдийн 90-ээс дээш хувь нь QPaу үйлчилгээг голлох төлбөрийн хэрэгсэл болгон ашиглаж байгаа нь онлайн бизнесүүдийг тогтвортой үйл ажиллагаа явуулахад нь чухал үүрэг гүйцэтгэж байна. Төрийн бүх үйлчилгээнд QPaу холболтыг хийснээр иргэд олон нийтийн төрийн үйлчилгээ авах хүртээмжийг нэмэгдүүлж, түгжрэл, цаг хугацаа хэмнэхэд бодитой хувь нэмэр оруулан ажиллаж байна.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Ерөнхий мэдээлэл

ТУЗ-ийн үйл ажиллагаа

ТУЗ-ийн гишүүд

Гүйцэтгэх удирдлагын баг

Компанийн бүтэц

Хувьцааны мэдээлэл

03



КОМПАНИ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр:
Инновэйшн Инвестмэнт ХК (QPAY)

Хэлбэр:
Хувьцаат компани

Регистрийн дугаар:
6183948

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:
Монголын Хөрөнгийн бирж

МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал:
II

Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:
184,889,160

Бизнесийн үндсэн үйл ажиллагааны салбар:

- Мэдээлэл технологийн үйл ажиллагаа
- Программ хангамжийн үйлчилгээ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Хувьцааны эзэмчигчдийн бүтэц:

27.45%	“Эн Си Ди Групп” ХХК
10.00%	Шагдарсүрэн Энхбаяр
8.42%	“Юнимедиа Солюшнс” ХХК
8.27%	“Могул” ХХК
7.30%	“ККТТ” ХХК
7.11%	“Айкор Партнерс” ХХК
5.61%	RENTTRACKS JSC
25.85%	Бусад хувьцаа эзэмшигчид

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо: 1,782
/Бүртгэлийн өдрөөр/

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн дүрэмд нийцүүлэн ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүн буюу нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгосон. Мөн 2024 оны 05 дугаар сарын -27ны өдөр хувьцаат компанийн “ТУЗ- ийн үйл ажиллагааны журам”-ийг шинэчлэн баталж, мөрдөн ажиллаж байна. Тус журамд ТУЗ- ийн бүрэн эрх, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, нэр дэвшүүлэх, гишүүн сонгох, чөлөөлөх, ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, ТУЗ-ийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн хурал, хуралдах журам, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн зардал, үйл ажиллагааг дүгнэх, ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулсан байдаг.

ТУЗ-ИЙН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

ТУЗ нь 2024 онд биечлэн, цахимаар, биечлэн болон цахим хосолсон, эчнээ санал хураалтын хэлбэрээр нийт 9 удаа, 77.8 % ба түүнээс дээш хувийн ирцтэй хуралдаж, 22 тогтоол шийдвэр гаргасан. 2024 онд Цалин урамшуулал, нэр дэвшүүлэлтийн хороо 3 удаа, Аудитын хороо 1 удаа хуралдаж, Эрсдэлийн удирдлагын хороо 1 удаа хуралдаж, Стратеги хөгжлийн хороо 1 удаа хуралдаж, хороодын чиг үүргийн хүрээнд хэлэлцсэн асуудлын талаар дүгнэлт, зөвлөмж гаргасан.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ-ийн дэргэд дор дурдсан хороод ажиллаж байна.

Үүнд:


- Аудитын хороо
- Цалин урамшуулал, нэр дэвшүүлэлтийн хороо
- Эрсдэлийн удирдлагын хороо
- Стратеги хөгжлийн хороо

ТУЗ-ИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

2024 онд Компанийн ТУЗ-ийн цалин, урамшуулал олгоогүй бөгөөд 2024 оны 5 дугаар сараас 2025 оны 4 дүгээр сар хүртэлх Компанийн ТУЗ-ийн цалин, урамшууллыг нөхөж олгохоор 2025 оны 4-р сарын 28-ны өдөр хуралдах ХЭЭХ-р хэлэлцүүлж, батлуулахаар төлөвлөж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Инновэйшн Инвестмент ХК нь IPO хийсний дараах хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит хурлаа 2024 оны 4 дүгээр сарын 28-ний өдөр хийсэн. Тус хурлаар Компанийн жилийн үйл ажиллагааны болон аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт батлах, Хувьцаат компанийн дүрмийн төслийг батлах болон ТУЗ-ийн гишүүдийг шинээр томилох үндсэн асуудлуудыг баталж шийдвэр гаргасан.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



ТУЗ-ИЙН ДАРГА
А.БАТТАМИР

Мэдээлэл технологийн салбарт
18 жил ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Д.ГАНЗОРИГ

Хөрөнгийн зах зээл, бизнес
санхүүгийн салбарт 16 жил
ажилласан туршлагатай.



ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Т.ДАШЦЭРЭН

Мэдээлэл технологийн салбарт
12 жил ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Ш. УЯНГА

Татвар, санхүүгийн салбарт 20
жил ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮН
Б.АНХБОЛД

Мэдээлэл технологийн салбарт
12 жил ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮН
Г.ХАТАНБОЛД

Хөрөнгө оруулалт, менежмент,
мэдээлэл технологийн салбарт
20 жил ажилласан туршлагатай




ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮН
Б.ЧУЛУУНСҮХ

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-
ийн үүсгэн байгуулагч, Мэдээлэл
технологийн салбарт 16 жил
ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮН
У.НАРАНБААТАР

Банк, санхүү, мэдээлэл
технологийн салбарт 20 жил
ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮН
У.МӨНХЗУЛ

“ЭН СИ ДИ ГРУПП ХХК”-н үйл
ажиллагаа хариуцсан захирал

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



Г. ЭРДЭНЭМӨНХ
CEO

2022 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.




Б. ЭНХБОЛД
CFO

2021 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Санхүү эрхэлсэн захирлаар ажиллаж байгаа.



О. ХОНГОР
CBO

2022 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирлаар ажиллаж байгаа.



Д.ЖАНЧИВ
СТО

2021 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Технологи хариуцсан захирлаар ажиллаж байгаа.



Ц.ГОМБОДОРЖ
CIO


2022 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирлаар ажиллаж байгаа.



С.ГҮРЖАВ
“ДИЖИТАЛ МЕРЧАНТ СЕРВИСЭС” ХХК

2019 оноос “Дижитал Мерчант Сервисэс” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа.

КОМПАНИЙН БҮТЭЦ | 2025 ОН




“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК-ИЙН БҮТЭЦ

2024 оны байдлаар “Инновэйшн Инвестмент” ХК нь охин компаниудын хамт нийт оны эцсийн байдлаар 39 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

ХУВЬЦААНЫ ХАНШ

2024 онд нийт 6.7 сая ширхэг хувьцаа 1.5 тэрбум төгрөгөөр арилжигдсан бөгөөд арилжааны дундаж ханш 223.26 төгрөг байлаа.



ДЭЭД ЦЭГ MNT 260.19

ДООД ЦЭГ MNT 209.70

EPS харьцаа 54.2 P/B харьцаа 2.60 P/E харьцаа 3.97

Өдрийн дундаж арилжаа

Хувьцааны тоо: 28.018 Арилжааны дүн: 6,217,554₮

Сарын дундаж арилжаа

Хувьцааны тоо: 555,685 Арилжааны дүн: 123,314,823₮

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

№	Хөрөнгө оруулалтын зориулалт	Эзлэх хувь	Татан төвлөрүүлсэн мөнгөн дүн	Зарцуулсан дүн
1	Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааны тэлэлт	22.5%	1,871,991,911	135,948,166
2	Дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа	30.0%	2,495,989,215	0
3	Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа	15.0%	1,247,994,608	1,061,274,656
4	“ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр	25.0%	2,080,003,050	2,080,003,050
5	Олон улсын зах зээлд үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбогдуулан хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулах	7.5%	623,985,266	0
НИЙТ		100.0%	8,319,964,050	3,277,225,872

- 2023 оны 12 дугаар сард нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 25% буюу “ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр болох 2,080,003,050 төгрөгийг зориулалтын дагуу ККТТ ХХК руу шилжүүлсэн.
- 2024 онд төлөвлөж байсны дагуу QPay төлбөрийн системийн суурь дэд бүтцийн шинэчлэлийн хүрээнд Суурь дэд бүтцийн сервер, тоног төхөөрөмжийг шинээр худалдаж авах болон одоогийн сервер, тоног төхөөрөмжийг өргөтгөх чиглэлээр 1,061,274,656 төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авалт хийсэн бөгөөд үүнийг татан төвлөрүүлсэн хөрөнгийн 15% буюу “Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа”-нд зориулагдах 1,247,994,608 төгрөгөөс зарцуулсан.
- Мөн 2024 оны 2 дугаар хагаст QPay үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлж, бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааг өргөжүүлэхтэй холбоотой кампанит ажлыг явуулж байгаа ба тус үйл ажиллагаатай холбоотой 135,948,166 төгрөгийн зардал гарсан. Үүнийг татан төвлөрүүлсэн хөрөнгийн “Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үйл ажиллагааны тэлэлт” хэсгээс зориулалтын дагуу зарцуулаад байна.
- Бид одоогоор нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 39%-ийг зориулалтын дагуу зарцуулаад байгаа ба үлдсэн хөрөнгийг зориулалтын дагуу 2025 болон 2026 онуудад зарцуулахаар төлөвлөж байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлан

Орлого үр дүнгийн тайлан

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мөнгөн гүйлгээний тайлан

04





“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Хараат бус аудиторын дүгнэлт

Далай тауэр, 9 давхар
ЮНЭСКО-ийн гудамж-31
Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Улаанбаатар
14230, Монгол Улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Инновэйшн Инвестмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид Инновэйшн Инвестмент ХК (цаашид “компани” гэх) болон түүний охин компаниуд (хамтад нь “групп” гэх) -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангуудад (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан,
- Нэгтгэсэн ашиг алдагдал, ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан
- Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл болон бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, Инновэйшн Инвестмент ХК болон түүний салбар компаниуд (хамтад нь “групп” гэх) -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх Нэгтгэсэн санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав.

Хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын Ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус группээс хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.



Аудитын аргачлалын хураангуй

Аудитын цар хүрээ	Энэхүү аудитын цар хүрээнд тус группийн охин компаниуд болох “ККТТ” ХХК болон “Дижитал Мерчант Сервисэс” ХХК багтсан болно
Материаллаг байдал	Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал нь 391,398.2 мянган төгрөг ба материаллаг байдлыг сонгохдоо татварын өмнөх ашгийн 3%-иар тооцсон.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Группийн удирдлага эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь нэгтгэсэн санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ группийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах группийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Нэгтгэсэн санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс нэгтгэсэн санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхийг ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас нэгтгэсэн санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Группийн дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.



- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй, байдлыг үнэлдэг.

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн группийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал групп тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Тодруулгыг багтаагаад нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж нэгтгэсэн санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилгоор компани доторх бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээллийн талаар хангалттай зохистой нотолгоо олж авдаг. Бид группийн аудитыг чиглүүлэх, хянах, гүйцэтгэх үүрэгтэй. Бид зөвхөн өөрсдийн аудитын дүгнэлтдээ хариуцлага хүлээнэ.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд доголцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Аудитын тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг “Компанийн тухай” хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон гэрээт ажлын Партнёр нь Н.Эрдэнэцог болно.



Огноо:



Огноо:

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Хөрөнгө	2023	2024
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	13,999,820	14,653,598
Дансны авлага	1,427,598	2,444,663
Татвар, НДШ-ийн авлага	14,611	2,019
Бусад авлага	415,741	563,558
Бусад санхүүгийн хөрөнгө	1,924,531	944,832
Бараа материал	2,020	2,737
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	80,549	114,825
Эргэлтийн хөрөнгийн дүн	17,864,869	18,726,232
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	624,074	1,229,171
Биет бус хөрөнгө	216,070	505,973
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	1,250,000
Хойшлогдсон татварын хөрөнгө	58,711	-
Эргэлтийн бус хөрөнгө	898,855	2,985,145
Нийт хөрөнгө	18,763,724	21,711,376
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	805,601	1,361,785
Цалингийн өглөг	37,543	47,166
Татварын өр	433,808	1,248,784
НДШ-ийн өглөг	393	3,249
Хүүний өглөг	23	-
Ногдол ашгийн өглөг	-	3,697,783
Урьдчилж орсон орлого	1,800	-
Богино хугацаат өр төлбөр	617	1,117
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,279,784	6,359,884
Урт хугацаат өр төлбөр		
Хойшлогдсон татварын өр		71,576
Бусад урт хугацаат өр төлбөр	36,372	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	36,372	71,576
Өр төлбөрийн нийт дүн	1,316,156	6,431,460
Капитал ба нөөц		
Хувьцаат капитал	4,425,440	4,284,927
Нэмж төлөгдсөн капитал	4,653,188	3,554,513
Хүримтлагдсан ашиг	8,368,939	7,440,476
Эзэмшигчдийн өмчийн дүн	17,447,568	15,279,917
Өр төлбөр болон эзэмшигчдийн өмчийн дүн	18,763,724	21,711,376

мянган төгрөгөөр

АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	2023	2024
Борлуулалтын орлого	13,237,510	26,231,629
Борлуулалтын өртөг	6,041,015	12,051,045
Нийт ашиг (алдагдал)	7,196,496	14,180,584
Борлуулалт, маркетингийн зардал	564,484	805,563
Ерөнхий ба удирдлагын зардал	1,698,693	1,941,064
Бусад орлого	1,210,184	-
Бусад зардал	161,084	45,307
Үйл ажиллагааны цэвэр ашиг	5,982,418	11,388,649
Хүүний орлого	414,802	1,608,190
Ногдол ашгийн орлого	-	69,105
Санхүүгийн зардал	12,897	2,188
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(4,164)	(13,528)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	74	(3,622)
Бусад ашиг (алдагдал)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	6,380,232	13,046,606
Орлогын татварын зардал	(684,069)	(3,020,452)
Татварын дараах ашиг (алдагдал)	5,696,163	10,026,154
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг	5,696,163	10,026,154
Нэгж хувьцаанд ноогдох ашиг суурь ашиг	31	54

мянган төгрөгөөр

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН


	2023	2024
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	14,678,301	29,286,589
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн орлого	13,761,945	27,842,043
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	35	233
Буцаан авсан албан татвар	47,795	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	868,525	1,444,313
Мөнгөн зарлагын дүн	11,709,895	20,491,649
Ажиллагчдад төлсөн	1,279,773	1,558,490
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	340,015	414,988
Бараа материал худалдан авахад төлсөн	9,472	8,518
Ашиглалтын зардалд төлсөн	-	20,994
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	157	392
Хүүний төлбөрт төлсөн	-	-
Татварын байгууллагад төлсөн	1,668,329	5,300,249
Даатгалын төлбөрт төлсөн	2,813	-
Бусад мөнгөн зарлага	8,409,338	13,188,019
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,968,406	8,794,940
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	4,452,376	1,975,403
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	3,992,456	414,630
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	46,916	267,021
Хүлээн авсан хүүний орлого	413,004	1,228,103
Хүлээн авсан ногдол ашиг	-	65,648
Мөнгөн зарлагын дүн	3,882,164	3,609,439
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	81,032	1,287,015
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	100,000
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	3,653,247	2,215,904
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	147,885	6,520
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	570,212	(1,634,036)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	8,747,873	103,027
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	10	103,027
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	8,747,864	-
Төрөл бүрийн хандив	-	-
Ханшийн зөрүүний олз	-	-
Мөнгөн зарлагын дүн	136,283	6,613,111
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	136,283	38,041
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	-	6,575,070
Ханшийн зөрүүний гарз	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,611,591	(6,510,084)
Валютын ханшийн зөрүү	(3,748)	2,959
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	12,146,460	653,779
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,853,360	13,999,820
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,999,820	14,653,598

мянган төгрөгөөр

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг /алдагдал	Нийт
2023 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	-	2,668,161	6,169,161
НББ-ийн тооцооллын бодлогын өөрчлөлтийн алдаа	-	4,615	4,615
Залруулсан үлдэгдэл	-	2,672,776	6,173,776
Тайлант жилийн ашиг	-	5,696,163	5,696,163
Өмчид гарсан өөрчлөлт	4,653,188	-	5,577,628
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	4,653,188	8,368,939	17,447,567
Өмчид гарсан өөрчлөлт (1)	(1,098,675)	-	(1,239,188)
Тайлант жилийн ашиг	-	10,026,154	10,026,154
Зарласан ногдол ашиг	-	(10,954,616)	(10,954,616)
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	3,554,513	7,440,477	15,279,917

мянган төгрөгөөр



INNOVATION
INVESTMENT



КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ





ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 05/31

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
ТАЛААР ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дүгээр заалт,
Компанийн дүрмийн 9.6.16 дугаар заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

- Инновэйшн Инвестмент ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг 1 дүгээр хавсралтаар гаргасугай.
- Гаргасан дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, батлуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/, Санхүү хариуцсан захирал /Б.Энхболд/ нарт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.БАТТАМИР

"Инновэйшн Инвестмент" ХК-ийн Төлөөлөн
удирдах зөвлөлийн хурлын 2025 оны 03 дугаар
сарын 17-ны өдрийн 05/31 тоот тогтоолын-1
дүгээр хавсралтаар батлав.



КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР
ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь Компанийн санхүүгийн тайлан гаргах ажиллагаа, дотоод хяналтын системийн хэвийн үйл ажиллагаа, аудитын үйл ажиллагаа, холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд компанийн зүгээс тавих хяналтын үйл ажиллагаа болон компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг дахин хянан нягталж энэхүү үйл ажиллагааны үр дүнг үндэслэн ТУЗ-д зөвлөмж гаргах, дотоод болон хөндлөнгийн аудитын хараат бус байдлыг баталгаажуулах, ТУЗ-ийн гишүүд, компанийн удирдлага ба дотоод болон хөндлөнгийн аудиторуудын үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй байна.

Инновэйшн Инвестмент ХК-ийн Аудитын хороо нь дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа.

Аудитын хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Ш.Уянга

Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Т.Дашицэрэн
ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Хатанболд

Инновэйшн Инвестмент ХК-ийн ТУЗ-өөс 2024 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэхээр Грант Торнтон Аудит ХХК-г сонгож, хамтран ажиллах гэрээ байгуулсан. Гэрээний дагуу тус компаниар хөндлөнгийн аудитыг хийлгүүлсэн бөгөөд санхүү бүртгэл, санхүүгийн тайлагналын хувьд СТОУС-д нийцсэн, ямар нэг зөрчилгүй дүгнэлт авсан байна.

Энэ онд тус хороо нь компанийн санхүүгийн хяналтын тогтолцоог сайжруулах үндсэн чиг үүргийнхээ дагуу сар бүрийн санхүүгийн тайлантай танилцаж үйл ажиллагаанд хяналт тавьж, чиглүүлэн ажиллалаа. Аудитын хорооны хурлаар тус компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт хийхдээ Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнхийн илтгэл, мөн хөндлөнгийн аудит хийсэн байгууллагын дүгнэлт, компанийн Санхүү удирдлагын газраас гаргуулсан мэдээ, мэдээллийг үндэслэл болгов.

Дүгнэх нь: Инновэйшн Инвестмент ХК нь үндсэн бизнесийн хувьд өөрийн охин компаниар дамжуулан бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд QRau үйлчилгээгээр хэрэглэгч, байгууллагуудад технологид суурилсан төлбөр тооцооны шийдлийг санал болгон ажиллаж байна. Тус системийн онцлог нь байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, бизнес эрхлэгчдэд санхүүгийн үүргээ биелүүлэх, мөнгөн хөрөнгөө аюулгүй, цаг тухайд нь шилжүүлэх боломжийг олгодог давуу талтай билээ. 2024 онд Компани нь оновчтой стратеги баримтлан төлөвлөсөн зорилго зорилтуудыг бүрэн биелүүлсний үр дүнд бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд амжилттай ажилласан байна.

2024 онд мерчантууд болон хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бөгөөд зах зээлд өрсөлдөхүйц анхдагч бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгохын зэрэгцээ өмнөх бааз сууриа бэхжүүлсэнээр тус онд QRau үйлчилгээгээр 176.6 сая ширхэг гүйлгээ хийсэн нь өмнөх оныхоос 46% -иар өссөн бол гүйлгээний үнийн дүнгийн хувьд өмнөх онтой харьцуулахад 80%-иар нэмэгдэж 10.6 их наяд төгрөгт хүрсэн байна.

Инновэйшн Инвестмент ХК нь 2023 оны 12 дугаар сард Монголын хөрөнгийн бирж дээр амжилттай IPO хийж, нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд үүний үр дүнд 2024 онд зах зээл дэх байр сууриа илүү тэлж, амжилттай ажиллах үндэс сууриа улам бэхжүүллээ.

Үүний үр дүнд 2024 онд борлуулалтаа нэмэгдүүлэн 10.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Мөн 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас 3.7 тэрбум төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэж, 2024.12 сард хувьцаа эзэмшигчдэдээ бүрэн хуваарилсан бол 2024 оны 2-р хагас жилийн цэвэр ашгаас дахин 3.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг олгохоор шийдвэрлэснээр өөрийн хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, өгөөжийг өсгөн ажилласан байна.

Монголын төлбөр тооцооны зах зээлд өөрсдийн байр сууриа бэхжүүлж, өрсөлдөхүйц бүтээгдэхүүнүүдийг санал болгон ажиллаж байгаа нь цаашид тогтвортой хөгжих суурийг сайн тавьсан гэж үзэн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооноос 2024 оны санхүүгийн үйл ажиллагааг хангалттай сайн гэж дүгнэж байна.


Инновэйшн Инвестмент ХК-ийн санхүүгийн тайлан, мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, санхүүгийн баримт материалын бүрдэл, компанийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ болон өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан заавар, журам аргачлал, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тайлагнасан болохыг танилцуулж байна.

Баталгаажуулсан:

Аудитын хорооны дарга:

Ш.Уянга

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ш.Уянга



INNOVATION
INVESTMENT



ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН
УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭГ БАТЛАХ,
НӨХӨН ОЛГОХ.

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

02




ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

- ХЭХ-ийн 2024 оны 4 сарын 28-ны өдрийн №01/03 тоот тогтоолоор одоогийн ТУЗ-ийн гишүүд сонгогдсон ба 2024 оны 5 дугаар сараас эхлэн ямар нэг цалин урамшуулал аваагүй үйл ажиллагаа явуулж байна. Иймд, ТУЗ-ийн гишүүдийн сарын цалинг дараах байдлаар тогтоож, 2024/05-2025/04 сарын хоорондох 12 сарын цалинг нөхөж нэг удаагийн урамшуулал байдлаар олгох, 2025 оны 05 дугаар сараас эхлэн сар бүр цалинг олгох санал гаргаж байна.
- ТУЗ-ийн хараат бус гишүүдийн сарын цалин 1,500,000 төгрөг
- ТУЗ-ийн ердийн гишүүдийн сарын цалин 800,000 төгрөг
- 2024/05 – 2025/04 сарын хоорондох нөхөж олгох 12 сарын цалингийн зардлын төсөв

	Гишүүдийн тоо	Сарын цалин /төгрөг/	Нийт сарын цалингийн зардал	Нөхөж олгох сар	Нийт цалингийн дүн	Байгууллагаас төлөх нийгмийн даатгалын зардал
ТУЗ-ийн хараат бус гишүүд	3	1,500,000	4,500,000	12	54,000,000	6,750,000
ТУЗ-ийн ердийн гишүүд	6	800,000	4,800,000	12	57,600,000	7,200,000
Нийт	9	2,300,000	9,300,000		111,600,000	13,950,000

- Нийт 125,550,000 төгрөгийн зардал гарах ба тус дүнг 2025 оны төсөвт суулгасан.



INNOVATION
INVESTMENT



КОМПАНИЙН ШИНЭЧИЛСЭН ДҮРЭМ БАТЛАХ

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ


03



КОМПАНИЙН ДҮРМИЙН ӨӨРЧЛӨЛТ



- Шинэ оффист нүүн орж, байршил өөрчлөгдсөнтэй холбоотой хаягийн өөрчлөлтийг Компанийн дүрэмд тусгахаар байна.
- Оффисын хуучин хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Элчингийн гудамж, Шүрэн оффис, 6 тоот
- Оффисын шинэ хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж, НМ төв, 8 давхар



INNOVATION
INVESTMENT



Компанийн 2024 оны цэвэр
ашгаас ногдол ашиг хуваарилах
эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг
танилцуулах.

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

04



НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭ

IPO хийснээс хойш нийт 11.4 тэрбум төгрөгийн ногдол ашиг хувиарлаад байна.

4.0

Ногдол ашиг олгохоор зарласан огноо:
2024/02/15-ны өдрийн 02/02 тоот тогтоол
Ногдол ашгаа хуваарилав.
2024/04/15

2023 оны жилийн эцэс

3.7

Ногдол ашиг олгохоор зарласан огноо:
2024/12/04-ний өдрийн 05/14 тоот тогтоол
Ногдол ашгаа хуваарилав.
2024/12/24

2024 оны I хагас

3.7

Ногдол ашиг олгохоор зарласан огноо:
2025/02/07-ны өдрийн 05/30 тоот тогтоол
Ногдол ашгаа 2025/04/30-ны өдрийн
дотор хувиарлахаар шийдвэрлэв.

2024 оны II хагас

18% НОГДОЛ
АШГИЙН
ӨГӨӨЖ

“Инновэйшн Инвестмент”ХК
нь 2024 онд нэг жхувьцаанд
40₮ ногдол ашиг
тарааж нийт **7.4 тэрбум төгрөг**
хуваарилахаар байна.



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр

Дугаар 05/14

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Инновэйшн Инвестмент ХК-ийн Ногдол ашгийн бодлогын 3 дугаар зүйлийн 3.6 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Компанийн 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 20 /хорь/ төгрөгөөр тогтоож, Компанийн 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгийн 70.1 /дал аравны нэг/ хувь буюу 3,697,783,200.00 /гурван тэрбум зургаан зуун ерэн долоон сая долоон зуун наян гурван мянга хоёр зуу/ төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
- Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөр тогтоосугай.
- Ногдол ашгаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуй нэгжийн орлогын албан татвар суутган тооцож, “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар ногдол ашгийг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор хуваарилахаар тогтоосугай.
- Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хуваарилах ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.БАТТАМИР



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар 05/30

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Инновэйшн Инвестмент ХК-ийн Ногдол ашгийн бодлогын 3 дугаар зүйлийн 3.6 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Компанийн 2024 оны хоёрдугаар хагас жилийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 20 /хорь/ төгрөгөөр тогтоож, Компанийн 2024 оны хоёрдугаар хагас жилийн цэвэр ашгийн 77.8 /дал долоо аравны найм/ хувь буюу 3,697,783,200.00 /гурван тэрбум зургаан зуун ерэн долоон сая долоон зуун наян гурван мянга хоёр зуу/ төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
- Компани нь 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 05/14 тоот тогтоолоор 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар зарласан ба нэгж хувьцаанд 20 /хорь/ төгрөг буюу нийт 3,697,783,200 төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр олгосон тул 2024 онд тайлант жилийн цэвэр ашгийн 73.8 /далан гурав аравны найм/ хувь буюу нийт 7,395,566,400 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилж байгааг дурьдсугай.
- Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
- Ногдол ашгаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуй нэгжийн орлогын албан татвар суутган тооцож, “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар ногдол ашгийг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хуваарилахаар тогтоосугай.
- Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хуваарилах ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.БАТТАМИР



ТОГТООЛЫН ТӨСӨЛ



КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР
ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Дугаар 01 Улаанбаатар хот

КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт “Инновэйшн Инвестмент” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 2025 оны 04 сарын 28-ны өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Инновэйшн Инвестмент” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

А.БАТТАМИР

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь Компанийн санхүүгийн тайлан гаргах ажиллагаа, дотоод хяналтын системийн хэвийн үйл ажиллагаа, аудитын үйл ажиллагаа, холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд компанийн зүгээс тавих хяналтын үйл ажиллагаа болон компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг дахин хянан нягталж энэхүү үйл ажиллагааны үр дүнг үндэслэн ТУЗ-д зөвлөмж гаргах, дотоод болон хөндлөнгийн аудитын хараат бус байдлыг баталгаажуулах, ТУЗ-ийн гишүүд, компанийн удирдлага ба дотоод болон хөндлөнгийн аудитуудын үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй байна.

Инновэйшн Инвестмент ХК-ийн ТУЗ-өөс 2024 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэхээр Грант Торнтон Аудит ХХК-г сонгож, хамтран ажиллах гэрээ байгуулсан. Гэрээний дагуу тус компаниар хөндлөнгийн аудитыг хийлгүүлсэн бөгөөд санхүү бүртгэл, санхүүгийн тайлагналын хувьд СТОУС-д нийцсэн, ямар нэг зөрчилгүй дүгнэлт авсан байна.

Энэ онд тус хороо нь компанийн санхүүгийн хяналтын тогтолцоог сайжруулах үндсэн чиг үүргийнхээ дагуу сар бүрийн санхүүгийн тайлантай танилцаж үйл ажиллагаанд хяналт тавьж, чиглүүлэн ажиллалаа. Аудитын хорооны хурлаар тус компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт хийхдээ Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнхийн илтгэл, мөн хөндлөнгийн аудит хийсэн байгууллагын дүгнэлт, компанийн Санхүү удирдлагын газраас гаргуулсан мэдээ, мэдээллийг үндэслэл болгов.

Дүгнэх нь: Инновэйшн Инвестмент ХК нь үндсэн бизнесийн хувьд өөрийн охин компаниар дамжуулан бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд QРау үйлчилгээгээр хэрэглэгч, байгууллагуудад технологид суурилсан төлбөр тооцооны шийдлийг санал болгон ажиллаж байна. Тус системийн онцлог нь байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, бизнес эрхлэгчдэд санхүүгийн үүргээ биелүүлэх, мөнгөн хөрөнгөө аюулгүй, цаг тухайд нь шилжүүлэх боломжийг олгодог давуу талтай билээ. 2024 онд Компани нь оновчтой стратеги баримтлан төлөвлөсөн зорилго зорилтуудыг бүрэн биелүүлсний үр дүнд бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд амжилттай ажилласан байна.

2024 онд мерчантууд болон хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бөгөөд зах зээлд өрсөлдөхүйц анхдагч бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгохын зэрэгцээ өмнөх бааз сууриа бэхжүүлсэнээр тус онд QРау үйлчилгээгээр 176.6 сая ширхэг гүйлгээ хийсэн нь өмнөх оныхоос 46% -иар өссөн бол гүйлгээний үнийн дүнгийн хувьд өмнөх онтой харьцуулахад 80%-иар нэмэгдэж 10.6 их наяд төгрөгт хүрсэн байна.

Инновэйшн Инвестмент ХК нь 2023 оны 12 дугаар сард Монголын хөрөнгийн бирж дээр амжилттай IPO хийж, нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд үүний үр дүнд 2024 онд зах зээл дэх байр сууриа илүү тэлж, амжилттай ажиллах үндэс сууриа улам бэхжүүллээ.

Үүний үр дүнд 2024 онд борлуулалтаа нэмэгдүүлэн 10.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Мөн 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас 3.7 тэрбум төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэж, 2024.12 сард хувьцаа эзэмшигчдэдээ бүрэн хуваарилсан бол 2024 оны 2-р хагас жилийн цэвэр ашгаас дахин 3.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг олгохоор шийдвэрлэснээр өөрийн хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, өгөөжийг өсгөн ажилласан байна.

Монголын төлбөр тооцооны зах зээлд өөрсдийн байр сууриа бэхжүүлж, өрсөлдөхүйц бүтээгдэхүүнүүдийг санал болгон ажиллаж байгаа нь цаашид тогтвортой хөгжих суурийг сайн тавьсан гэж үзэн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооноос 2024 оны санхүүгийн үйл ажиллагааг хангалттай сайн гэж дүгнэж байна.

Инновэйшн Инвестмент ХК-ийн санхүүгийн тайлан, мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, санхүүгийн баримт материалын бүрдэл, компанийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ болон өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан заавар, журам аргачлал, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тайлагнасан болохыг танилцуулж байна.



“Инновэйшн Инвестмент” ХК-ийн
2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
02-р тогтоолын 1-р хавсралт

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Дугаар 02 Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭГ БАТЛАХ, НӨХӨН ОЛГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дэх хэсэг, “Инновэйшн Инвестмент” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 2025 оны 04 сарын 28-ны өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн өмнөх 12 сарын хугацааны нөхөж олгох цалингийн зардлын төсөв болон цаашид олгох сар бүрийн цалингийн зардлын төсвийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
- Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороонд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

А.БАТТАМИР

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

- “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны нөхөж олгох цалин болон 2025 оны цалингийн зардлын төсөв.
Хүснэгт 1. 2024 оны 5 дугаар сараас эхлэн 2025 оны 04 дүгээр сар хүртэлх нийт 12 сарын нөхөж олгох цалингийн зардлын төсвийн задаргаа:

	Гишүүдийн тоо	Сарын цалин /төгрөг/	Нийт сарын цалингийн зардал	Нөхөж олгох сар	Нийт цалингийн дүн	Байгууллагаас төлөх нийгмийн даатгалын зардал
ТУЗ-ийн хараат бус гишүүд	3	1,500,000	4,500,000	12	54,000,000	6,750,000
ТУЗ-ийн ердийн гишүүд	6	800,000	4,800,000	12	57,600,000	7,200,000
Нийт	9	2,300,000	9,300,000		111,600,000	13,950,000
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд нөхөж олгох зардлын нийт дүн 125,550,000 төгрөг байна.						

- ТУЗ-ийн гишүүдийн сарын цалинг дараах байдлаар тогтооно. Үүнд:
 - ТУЗ-ийн хараат бус гишүүдийн сарын цалин 1,500,000 төгрөг
 - ТУЗ-ийн ердийн гишүүдийн сарын цалин 800,000 төгрөг



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ШИНЭЧИЛСЭН ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт , “Инновэйшн Инвестмент” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 2025 оны 04 сарын 28-ны өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Инновэйшн Инвестмент” ХК-ийн шинэчилсэн дүрмийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Компанийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх, баримт бичиг хүргэх, хүлээн авах болон энэхүү ажиллагаатай холбоотой шаардлагатай бусад эрхийг С.Гүржав /РД: ТБ81112013/-д итгэмжлэн олгосугай.

ХУРЛЫН ДАРГА

А.БАТТАМИР



САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР



“Инновэйшн Инвестмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 05/32 тоот тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлав.

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог нэр
Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Регистерийн дугаар

Санал өгөх хувьцааны тоо
Бүртгэсэн /Үнэт цаасны компани /
Брокерийн овог нэр

“Инновэйшн инвестмент” ХК-ийн **Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал** 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 15:00, /<https://agt.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр хуралдана.

Саналын хуудас бөглөх заавар: **Дараах хэлэлцэх асуудлуудыг ЕРДИЙН АРГААР санал хураана.**
Ердийн аргаар саналаа өгөхөд асуудал бүрээр “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” аль нь болохыг тэмдэглэнэ.

№	ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Санал
1.	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай	Тогтоол №1				
2.	ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах, нөхөж олгох тухай	Тогтоол №2				
3.	Компанийн шинэчилсэн дүрэм батлах тухай	Тогтоол №3				

Брокер: / /
/ гарын үсэг, тэмдэг /

Хувьцаа эзэмшигч: / /
/ гарын үсэг /

Саналын хуудсыг **хүчинтэйд** тооцов:/ /
Саналын хуудас **хүчингүйд** тооцсон бол шалтгаан:.....
.....
2025 оны сар өдөр

САНАЛЫН ХУУДСЫГ БӨГЛӨХ САНАМЖ:

Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө

1. Саналыг ердийн аргаар тоолох асуудалд:

- Тухайн асуудалд зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэсэн аль нэгд нь ✓ эсвэл + тэмдгээр санал аа өгнө.
- Засварласан, балласан, эсвэл болон аль нэг саналыг бөглөөгүй бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.



ВЭБ ХУУДАС: I-INVESTMENT.MN

ХОЛБОО БАРИХ: +976 76102211

И-МЭЙЛ ХАЯГ: INFO@QPAY.MN

ХАЯГ: МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, ХАН-УУЛ ДҮҮРЭГ, 15-Р

ХОРОО, МАХАТМА ГАНДИГИЙН ГУДАМЖ, НМ ОФФИС, 8 ДАВХАР